



365

**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Ажил дүгнэх журам, шалгуур үзүүлэлт
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоол, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч, ажиллагсдын ажил дүгнэх журмыг нэгдүгээр, ажил дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан эмч, ажиллагсдыг идэвхижүүлж, урамшуулах зорилгоор ажлын гүйцэтгэл, үр дүнг Засгийн газрын 2019 оны 05 дугаар тушаалаар батлагдсан журам, шалгуур үзүүлэлтээр сар бүр бодитой үнэлж дүгнэхийг Албадын дарга, хүүхдийн эмнэлгийн дарга, амбулаторийн чанарын болон халдварын сэргийлэлт хяналтын багуудад үүрэг болгосугай.

3. Ажил дүгнэх журам, шалгуур үзүүлэлтээр эмч, ажилтнуудын ажлыг сар бүр дүгнэж, улирал бүр Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн эмч, ажиллагсдад олгох үр дүнгийн урамшууллын үнэлгээ, хувь хэмжээг шийдвэрлүүлж ажиллахыг Ажил дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

4. Эмч ажилтанд олгох үр дүнгийн үнэлгээний урамшууллыг улирал бүр зохих зардлаас олгож байхыг Санхүүгийн албаны дарга /О.Золзаяа/-д зөвшөөрсүгэй.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 04 сарын 05-ны өдрийн А/32 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Ж.ЭНХЗУЛ

C:\Documents and Settings\Administrator\My Documents\Ajl\tushaal

3130700133

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
20.20 оны 04 дугаар сарын 15-ний өдрийн
А/57 дугаар тушаалын хавсралт 1



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭМЧ, АЖИЛЛАГСДЫН АЖИЛ ДҮГНЭХ ЖУРАМ**

Нэг. Журмын үндэслэл, Зорилго

1.1. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоол, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10.2.2 дахь заалтыг үндэслэн эмч, ажилтнуудын ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитой үнэлж урамшуулахад журмын зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журмыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэхэд дагаж мөрдөнө.

Гурав. Ажил дүгнэх аргачлал

3.1. Эрүүл мэндийн төвийн албадууд болон амбулаторийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын ажил үүргийн гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтээр сар бүр дүгнэнэ.

3.2. Удирдлагын зөвлөлийн гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хариуцсан алба, нэгжийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан байдал, боловсруулсан эрх зүйн баримт бичиг, үр дүн гэсэн шалгуурыг нэмэлтээр оруулна.

3.3. Ажил дүгнэсэн дүнг улирлаар Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар баталгаажуулна.

3.4. Эрүүл мэндийн төвийн Албадын дарга, Хүүхдийн эмнэлгийн дарга, Амбулаторийн эрхлэгч, Дотоод хяналтын ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг Эрүүл мэндийн төвийн дарга дүгнэнэ.

Дөрөв. Ажил дүгнэж үнэлгээ өгөх

4.1. Ажил дүгнэж буй дарга/эрхлэгч нь батлагдсан шалгуур үзүүлэлтүүдээр ажлын гүйцэтгэл, үр дүнг 100 хүртэл оноогоор үнэлж дүгнэнэ.

4.2. Нийт авсан онооны нийлбэрээр ажилтны ажлын гүйцэтгэл, үр чадварыг дараах байдлаар үнэлнэ.

90 – 100 оноо авсан бол “А” буюу “маш сайн”

71 – 89 оноо авсан бол “В” буюу “сайн”

Тав. Үнэлгээний тэмдэглэл

5.1. Эмч, ажилтан нь үнэлгээг зөвшөөрөхгүй бол шалгуурын дагуу ажлын гүйцэтгэл болон үндэслэлээ тусгаж, удирдлагын зөвлөлд хүсэлт гарган хурлаар шийдвэрлүүлнэ.


5.2. Үнэлгээ хийсэн ЭМТ-ийн дарга, хүүхдийн эмнэлгийн дарга, албадын дарга, амбулаторийн эрхлэгч, хүлээн зөвшөөрсөн ажилтан, гарын үсэг зурснаар үнэлгээ баталгаажина.

Зургаа. Үнэлгээний урамшуулал

6.1. Ажилтны авсан үнэлгээний дагуу ур чадварын нэмэгдлийг дараах байдлаар сар бүрээр тооцож улиралд нэг удаа олгоно.

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (сард)
90-100	А	11-20 хувь хүртэл
71-89	В	10 хувь хүртэл

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
2020 оны 04 дугаар сарын 15-ний өдрийн
1/57 дугаар тушаалын хавсралт 2



АЖИЛ ДҮГНЭЖ ҮНЭЛГЭЭ ХИЙХ БҮРЭЛДЭХҮҮН

№	Дүгнүүлэх ажилтан	Дүгнэх ажилтан
1.	Албадын дарга, Амбулаторийн эрхлэгч, Хүүхдийн эмнэлгийн дарга, Дотоод хяналт хариуцсан ажилтан	ЭМТ-ийн дарга
2.	Эмч, Сувилагч, Эмнэлгийн тусгай мэргэжилтэн, амбулаторийн бусад үйлчилгээний ажилтнууд	Амбулатори, хүүхдийн эмнэлгийн чанарын болон халдварын сэргийлэлт хяналтын баг
3.	Хүүхдийн эмнэлгийн Эмч, Сувилагч, Эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад үйлчилгээний ажилтнууд	Хүүхдийн эмнэлгийн дарга
4.	Чанарын менежер	Чанарын албаны дарга
5.	НҮЭМ-ийн ерөнхий зохицуулагч	ЭЭОрлогч дарга
6.	Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэнд хариуцсан ерөнхий зохицуулагч	ЭЭОрлогч дарга
7.	Эм зүйч, Клиник эм зүйч	Эмийн эмчилгээний хорооны дарга, Санхүүгийн албаны дарга
8.	Эм найруулагч	Санхүүгийн албаны дарга
9.	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан	НЭМ-ийн Орлогч дарга
10.	Өрхийн менежер	НЭМ-ийн Орлогч дарга
11.	Сургалтын менежер	НЭМ-ийн Орлогч дарга
12.	ХБӨ хариуцсан мэргэжилтэн	НЭМ-ийн Орлогч дарга
13.	Хоол зүйч	НЭМ-ийн Орлогч дарга
14.	Халдвар судлагч	НЭМ-ийн Орлогч дарга
15.	Өсвөр үе залууст ээлтэй клиникийн эмч	НЭМ-ийн Орлогч дарга
16.	Өсвөр үеийн эмч	НЭМ-ийн Орлогч дарга, амбулаторийн чанарын болон халдварын сэргийлэлт хяналтын баг
17.	БЗДХ/ХДХВ/ДОХ-ын диспансерийн зохицуулагч	НЭМ-ийн Орлогч дарга, поликлиникийн эрхлэгч
18.	Сүрьеэгийн диспансерийн зохицуулагч	НЭМ-ийн Орлогч дарга, поликлиникийн эрхлэгч
19.	Эрт илрүүлэг хариуцсан мэргэжилтэн	НЭМ-ийн Орлогч дарга
20.	Мэдээллийн технологийн ажилтан	СМЗАлбаны дарга

21.	Статистикч бага эмч	СМЗАлбаны дарга
22.	Сувилахуйн арга зүйч	Сувилахуйн албаны дарга
23.	Архив, бичиг хэргийн ажилтан	Хүний нөөцийн албаны дарга
24.	Төлөвлөлт, дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	Хүний нөөцийн албаны дарга
25.	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан	Хүний нөөцийн албаны дарга
26.	Цалингийн нягтлан бодогч	Санхүүгийн албаны дарга
27.	Тооцооны нягтлан бодогч	Санхүүгийн албаны дарга
28.	Нярав	Санхүүгийн албаны дарга
29.	Эрүүл мэндийн даатгалын мэргэжилтэн	Санхүүгийн албаны дарга
30.	Сантехникийн слесарь	ХҮИТАлбаны дарга
31.	Жолооч	ХҮИТАлбаны дарга
32.	Цахилгаанчин	ХҮИТАлбаны дарга
33.	Мужаан	ХҮИТАлбаны дарга